



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2018 оны 12 сарын 18 өдөр

Дугаар A/248

Улаанбаатар хот

Санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах  
журам батлах тухай


Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, "ШУТИС-ийн дүрэм"-ийн 4.14.7 дахь заалт, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "ШУТИС-ийн санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. Батлагдсан журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал (Л.Баяр-Эрдэнэ)-д, санхүүгийн үйл ажиллагаандaa мөрдөж, хэрэгжүүлэн ажиллахыг бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн захирал, ахлах няглан бодогч наарт даалгасугай.
3. Энэ тушаалыг гарсантай холбогдуулан ШУТИС-ийн захирлын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/236 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "ШУТИС-ийн санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

Б.ОЧИРБАТ





## ШУТИС-ИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

### 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Монгол улсын Төсвийн тухай хуулиар зөвшөөрөгдсөн санхүүжилтийн зарчмыг үндэс болгон төрийн өмчийн оролцоотой байгууллагын үйл ажиллагааны зорилтыг хангахад чиглүүлэх, төсвийн төлөвлөлтийн зарцуулалт, төсвийн гүйцэтгэл, тайлagnalтай холбогдсон зохицуулалт, төсвийн хуваарилалтыг боловсронгуй болгох, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцлийг хангах, санхүүгийн дотоод хяналтын үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2 Энэ журам нь ШУТИС Төв, ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци, Захиргаа, бүрэлдэхүүн сургууль, бусад нэгжүүдийн /цаашид “нэгж” гэх/ удирдлагын санхүүгийн үйл ажиллагааны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлно.
- 1.3 Энэхүү журмыг ШУТИС-ийн Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэн, ШУТИС-ийн Захирлын тушаалаар баталж мөрдөнө.
- 1.4 Журамд оруулах нэмэлт өөрчлөлтийг ШУТИС-ийн Санхүүгийн асуудал эрхэлсэн дэд захирлын санаачлагаар ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ШУТИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна.

### 2. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Энэхүү журмыг ШУТИС-ийн захиргааны болон бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн удирдлага, санхүүгийн ажилтнууд дагаж мөрдөнө.

### 3. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ШУТИС-ийн дүрэм
- ШУТИС-ийн nyaгтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

### 4. ҮНДСЭН ОЙЛГОЛТ

- 4.1 Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн орлогын үндсэн эх үүсвэр нь Дээд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан улсын төсвийн орлого, сургалтын төлбөрийн орлого, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төслийн орлого, аж ахуйн үйл ажиллагааны орлого, аж ахуй нэгж байгууллагын иргэдийн хандив, зээл тусламж, бусад эх үүсвэрийн орлогоос бүрдэнэ. Эдгээр орлогын эх үүсвэрийг ШУТИС-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт

- бичигт тусгасан нийтлэг бус татварын орлого, хөрөнгийн орлого, тусlamжийн орлого, санхүүжилтийн орлого, бусад орлого гэсэн төрлүүдэд ангилна.
- 4.2 Нийтлэг татварын бус орлого нь хүүгийн орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого, түрээсийн орлогоос бүрдэнэ. Үндсэн үйл ажиллагааны сургалтын төлбөрийн орлого нь ахлах сургуулийн, бакалаврын, бакалаврын эчнээ, бакалаврын өвөл зуны, магистрын, докторын сургалтын төлбөрийн орлогоос бүрдэнэ. Эрдэм шинжилгээ, судалгааны орлого нь дотоод, гадаад төсөл, гэрээт ажил, инновацийн орлогоос бүрдэнэ.
- 4.3 Үндсэн бус үйл ажиллагааны сургууль хоорондын тооцооны орлого нь ШУТИС Төв, ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн бие биедээ үзүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний болон бакалавр, магистр, докторын сургалтын төлбөрийн орлогын төвлөрүүлэлт, сургалтын төлбөрийн орлогын төвлөрүүлэлтээс олгосон сургалтын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, эрсдлийн арга хэмжээний санхүүжилт, тодорхой зорилго, зориулалтыг хангах хүрээнд дотооддоо шилжүүлсэн төвлөрсөн арга хэмжээний төвлөрүүлсэн орлогуудаас бүрдэнэ.
- 4.4 Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд тухайн хичээлийн жилд үүссэн сургууль хоорондын тооцоог тогтоосон журмын дагуу бүрэн хийн барагдуулах үүрэгтэй бөгөөд энэ нь бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн өөр хоорондоо үзүүлсэн үйлчилгээний хөлс юм.
- 4.5 Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн зарлагын үндсэн эх үүсвэр нь Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 07 тоот, Гэгээрлийн сайдын 1999 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 107 тоот тушаалын зардлын ангилалд заасны дагуу сургалттай холбоотой шууд зардал, шууд бус зардал, оюутны үйлчилгээний зардал, инновацийн үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалтын зардалд суурисан ШУТИС-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан зардлын төрлүүдтэй байна.
- 4.6 Сургалттай холбоотой шууд зардал нь сургалтын үйл ажиллагаанд оролцогч багш, ажиллагчдын цалин, хөлстэй холбогдох зардал, хичээл практикийн зардал, ном хэвлэл, багшийг дэмжих болон тэдний мэргэжил дээшлүүлэх зардал, томилолтын зардал, байр ашиглалттай холбоотой зардал, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зардлуудаас бүрдэнэ. Харин эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааны зардал нь эрдэм шинжилгээний ажилтны цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, эрдэм шинжилгээний зардал, инновацийн зардлаас бүрдэнэ.
- 4.7 Шууд бус сургууль хоорондын тооцооны зарлага нь сургалтын төлбөрийн орлогын төвлөрүүлэлт, сургалтын төлбөрийн орлогын төвлөрүүлэлтээс олгосон сургалтын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, эрсдлийн арга хэмжээний санхүүжилт, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн бие биедээ үзүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний төвлөрүүлэлт болон тодорхой зорилго, зориулалтыг хангах хүрээнд дотооддоо шилжүүлсэн төвлөрүүлэлтийн зарлагаас бүрдэнэ.
- 4.8 ШУТИС-ийн төсвийн үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Дээд боловсролын тухай хуулийн хүрээнд зохицуулагдана. Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд тухайн жилийн төсвийн төслөө Хөгжлийн

хөтөлбөр, төлөвлөлтийн асуудал хариуцсан газар албаны гаргасан дүрэм, журам, удирдамжийн дагуу заасан хугацаанд хэлэлцүүлж боловсруулна. ШУТИС-ийн нэгдсэн төсөв, төлөвлөгөөг тухайн төсвийн жилийн өмнөх оны 12 дугаар сард Хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн асуудал хариуцсан газар, албанаас ШУТИС-ийн Захирлын зөвлөл, Удирдах зөвлөлөөр тус тус хэлэлцүүлэн батлуулж, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдэд хүргүүлнэ.

## 5. САНХҮҮГИЙН НЭГЖҮҮДИЙН БҮТЭЦ

- 5.1 Сургуулийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа бүх нэгжүүдийг өөрийгөө санхүүжүүлэх нөхцөл, үйл ажиллагааны онцлог, үйл ажиллагааны зорилго, зориулалтаас харгалзан дараах байдлаар ангилна. Үүнд:
- Удирдлагаар хангаж, санхүүгийн тайлангаа нэгтгэдэг бүрэлдэхүүн нэгж: ШУТИС Төв, ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци, Захиргаа, Бүрэлдэхүүн сургуулиуд, ШУТИС Коосэн Технологийн коллеж, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургууль, ШУТИС Хэвлэлийн газар, ШУТ-ийн Төв номын сан, Ой модны сургалт, судалгааны хүрээлэн
  - Удирдлагаар хангадаг боловч санхүүгийн тайлангаа нэгтгэдэггүй бүрэлдэхүүн нэгж: ШУТИС-ийн харьяа Уул уурхайн хүрээлэн, Дулаан техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн, Хөнгөн үйлдвэр, судалгаа хөгжлийн хүрээлэн
  - Удирдлагаар хангадаггүй боловч санхүүгийн тайлангаа нэгтгэдэг бүрэлдэхүүн нэгж: Эрдэмнэт сүлжээний төв
- 5.2 ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан ШУТИС-ийн жилийн төсвийг тухайн санхүүгийн жилдээ баримтлан ажиллана.
- 5.3 Төсвийн тухай хууль, ШУТИС-ийн дүрэм, ШУТИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам, ШУТИС-ийн Захирал, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн удирдлагатай байгуулсан Хөдөлмөрийн гэрээ, Үр дүнгийн гэрээний дагуу эрх бүхий албан тушаалтнууд төсвийн гүйцэтгэлтэй холбоотой эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- 5.4 Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд нь үндсэн үйл ажиллагааны орлогоос гадна хуулийн хүрээнд бусад үйл ажиллагааг явуулан нэмэлт орлого олоход идэвх санаачлагатай ажиллана.
- 5.5 Бүрэлдэхүүн сургуулиуд сургалтын үйл ажиллагааны зардлаас бусад үйл ажиллагааны зардлыг өөрсдөө санхүүжүүлнэ. Үүнд: оюутны байр, төсөл, гэрээт ажил, түр сургалт, үйлдвэрлэл үйлчилгээ гэх мэт
- 5.6 Дараах нэгжүүд нь санхүүгийн хувьд бие даан үйл ажиллагаа явуулна. Үүнд: ШУТИС-Коосэн Технологийн коллеж, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургууль, Ой модны сургалт, судалгааны хүрээлэн, ШУТИС-Хэвлэлийн газар, Эрдэмнэт сүлжээний төв
- 5.7 Санхүү, нягтлан бодох бүртгэлийн асуудал хариуцсан газар, албанаас Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгааг төсвийн гүйцэтгэлээр тодорхойлж сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал бүрээр бэлтгэнэ.
- 5.8 Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд Санхүү, нягтлан бодох бүртгэлийн асуудал хариуцсан газар, албанад төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бурийн 01-ны

дотор, улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 10-ны дотор, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн асуудал хариуцсан газар, алба сарын гүйцэтгэлийн мэдээг дараа сарын 02-ны дотор, нэгдсэн санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор нэгтгэнэ.

- 5.9 Санхүү, нягтлан бодох бүртгэлийн асуудал хариуцсан газар, алба нь Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу бүрэлдэхүүн нэгжүүдийн нэгтгэсэн сар, улирлын төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор, хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өнгөрсөн жилийн санхүүгийн аудитын дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын shilendans.gov.mn интернет хуудасд байрлуулж олон нийтэд мэдээлнэ.
- 5.10 ШУТИС-ийн төсвийн хөрөнгө оруулалт, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Барилгын тухай хууль, Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмыг дагаж мөрдөнө. Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа нь холбогдох дүрэм, журам, Хөрөнгө оруулалт, хангамжийн асуудал хариуцсан газар, албаны гаргасан удирдамжийн дагуу зохицуулагдана.

## 6. ЗАХИРГААНЫ САНХҮҮГИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1 Тайлант жилийн төсвийн санхүүжилт, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн орлогын эх үүсвэрүүдийг захиргаа өөрийн орлого гэж хүлээн зөвшөөрнө.
- 6.2 Эрүүл мэндийн үзлэгийн орлого, элсэлтийн болон бүртгэлийн хураамжийн орлого, ахисан түвшний сургалтын шалгалтын төлбөр зэргийг захиргааны өөрийн орлого гэж үзнэ.
- 6.3 Захиргаа нь ШУТИС Төвөөс санхүүжилт авах ба энэ нь захиргаа, эрүүл мэндийн төв болон нийтлэг үйлчилгээний зардлыг санхүүжүүлнэ.
- 6.4 ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн шийдвэрээр, тодорхой арга хэмжээний зориулалтаар хуваарилагдсан орлогыг цаг тухай бүр, эсвэл улирал бүрийн санхүүгийн тайлагналын хугацаанд бүрэлдэхүүн нэгжүүдтэй тооцоо нийлж тулган баталгаажуулна.
- 6.5 Захиргаа нь батлагдсан төсвийн хуваарийн дагуу ШУТИС Төвөөс сар бүр санхүүжилт авах ба уг санхүүжилт болон өөрийн үйл ажиллагааны бусад орлогын эх үүсвэрээс бусад бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдэд журмаас гадуур ямар нэг санхүүжилт хийж болохгүй.
- 6.6 Захиргааны хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн шийдвэрийн дагуу ШУТИС Төвөөс тухайн жилийн нийт зардлын 10 хувиас ихгүй хэмжээгээр нэмж татаас санхүүжилт авч болно. Уг татаас санхүүжилтийн зардлыг төсвийн тодотголоор баталгаажуулна.
- 6.7 Захиргаа нь төсвийн гүйцэтгэлийг ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хуралд тайлагнана.
- 6.8 Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 6.6.3-ийн дагуу санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захиралд сургалттай холбоотой шууд болон

шууд бус зардал, оюутны үйлчилгээний зардал, хөрөнгө оруулалтын зардлын зарцуулалтын эрхийг хэсэгчлэн болон бүгдийг тэрээгээр шилжүүлэн өгч болно.

## 7. ШУТИС ТӨВИЙН САНХҮҮГИЙН ЭРХ, ҮҮРЭГ


- 7.1 Тайлант жилийн төсвийн санхүүжилт, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн орлогын эх үүсвэрүүдээс бүрдэх төвлөрөлийг ШУТИС Төв өөрийн орлого гэж хүлээн зөвшөөрнэ.
- 7.2 Эрсдэлийн санхүүжилт дансанд төвлөрсөн хүүний орлогыг ШУТИС Төвийн орлого гэж үзнэ.
- 7.3 ШУТИС Төв нь Ургал санхүүжилт, Хөрөнгө оруулалтын санхүүжилт, Эрсдлийн санхүүжилт гэсэн дансуудтай байна.
- 7.4 Ургал санхүүжилт дансанд бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын төлбөрийн орлогын төвлөрүүлэлт, Боловсролын зээлийн сангийн болон улсын төсвийн санхүүжилтийн орлого орно.
- 7.5 Бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын төлбөрийн орлогын дансны үлдэгдлийг сар бүрийн эцэст Ургал санхүүжилт дансанд татан төвлөрүүлнэ.
- 7.6 Ургал санхүүжилт дансанд төвлөрсөн сургалтын төлбөрийн нийт орлогын 10%-ийг Хөрөнгө оруулалтын санхүүжилт дансанд, 5%-ийг Эрсдлийн санхүүжилт дансанд тус тус хуваарилан сар бүрийн эцэст шилжүүлнэ.
- 7.7 Ургал санхүүжилт данснаас Боловсролын зээлийн сангийн болон улсын төсвийн санхүүжилтийг (тогтмол зардлын) бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдэд холбогдох тооцоог үндэслэн санхүүжилт орж ирсэн тухай бүрт шилжүүлнэ.
- 7.8 Бүрэлдэхүүн сургуулиудын тухайн жилийн батлагдсан төсвийн хуваарь, нэхэмжлэхийг үндэслэн сар бүрийн эхний ажлын 5 хоногийн дотор сургалтын үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг тухайн сард бүрэлдэхүүн сургуулиудад шилжүүлсэн Боловсролын зээлийн сангийн болон улсын төсвийн санхүүжилтийг хассан дүнгээр Ургал санхүүжилт данснаас хуваарилан олгоно.
- 7.9 Бүрэлдэхүүн сургуулиуд нь тухайн сарын санхүүжилт зардлаа санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй тохиолдолд Санхүүгийн асуудал хариуцсан дэд захиралд хүсэлт гарган, дараа сарын санхүүжилтээс урьдчилан авч болно.
- 7.10 Ургал санхүүжилт данснаас сар бүрийн эхэнд Захиргаа, Шинжлэх ухаан технологийн төв номын сангийн тухайн жилийн батлагдсан төсвийн хуваарь, нэхэмжлэхийг үндэслэн санхүүжилт олгоно.
- 7.11 Ургал санхүүжилт данснаас орлогын бүрдүүлэлт тасалдсан, санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцэхгүй бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдэд ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн сургалттай холбоотой шууд зардлыг олгож болно.
- 7.12 Хөрөнгө оруулалтын санхүүжилт данснаас сар бүр бүрэлдэхүүн сургууль, нэгжийн тухайн жилд батлагдсан хуваарийн дагуу хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлнэ.
- 7.13 Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн тухайн жилийн батлагдсан төсвийн хуваарь, нэхэмжлэх, Хөрөнгө оруулалт, хангамжийн асуудал хариуцсан газар, албаны шийдвэрийг үндэслэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны санхүүжилтийг ажлын 5 хоногийн дотор олгоно.

- 7.14 Хөрөнгө оруулалт, хангамжийн асуудал хариуцсан газар, алба нь ШУТИС-ийн тухайн төсвийн жилийн хөрөнгө оруулалт, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдээс холбогдох саналуудыг авч нэгтгэн боловсруулж ШУТИС-ийн Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэн, Удирдах зөвлөлөөр батлуулна.
- 7.15 Эрсдлийн санхүүжилт данснаас бүрэлдэхүүн сургууль, нэгжийн тухайн жилд үүссэн санхүүгийн эх үүсвэрийн дутагдал, урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас гэнэтийн үйл явдалтай хамааралтай төсөвт тусгагдаагүй зардлыг санхүүжүүлэх, мөн сургалтын төлбөрийн буцаалтыг олгоход зарцуулна.
- 7.16 Бүрэлдэхүүн сургууль, нэгжийн тухайн жилд үүссэн санхүүгийн эх үүсвэрийн дутагдал, урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас гэнэтийн үйл явдалтай хамааралтай төсөвт тусгагдаагүй зардлыг санхүүжүүлэхдээ ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хурлын шийдвэр болон холбогдох бусад материалыг үндэслэнэ.
- 7.17 Эрсдлийн санхүүжилт данснаас сургалтын төлбөрийн буцаалтыг бүрэлдэхүүн сургуулиудаас ирүүлсэн тооцоо, нэхэмжлэхийн дагуу сар бүрийн эцэст төвлөрүүлсэн орлогоос бүрэлдэхүүн сургуулиудад шилжүүлнэ.
- 7.18 ШУТИС Төвөөс Бүрэлдэхүүн нэгжүүдийн урсгал, хөрөнгө оруулалтын санхүүжилтын гүйлгээ батлагдсан төсвөөс хэтрэх тохиолдолд Төлөвлөлтийн болон Санхүүгийн асуудал хариуцсан дэд захирлуудын зөвшөөрөл, шийдвэрийн дагуу нэмэлт санхүүжилт олгож болно.
- 7.19 ШУТИС Төв нь төвлөрүүлсэн орлого, өөрийн үйл ажиллагааны орлогын эх үүсвэрээс зардлын гүйлгээ хийж болохгүй.
- 7.20 ШУТИС Төв нь төвлөрүүлсэн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийн тооцоог ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хуралд тайлагнана.
- 7.21 Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн зардлын зүйл ангийн аливаа хэтрэлтийг ШУТИС Төв хариуцахгүй.
- 7.22 Шаардлагатай гэж үзвэл бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн тухайн сарын зарцуулалтын тайлант Санхүү, нягтлан бодох бүртгэлийн асуудал хариуцсан газар, албанаас шалгаж дүнг Захиргаанд мэдээлнэ. Онцгой тохиолдолд зарим бүрэлдэхүүн сургууль, нэгжийн санхүүгийн төлбөр тооцоог Захиргаанаас тодорхой хугацаагаар хязгаарлах болон түр зогсоож болно.
- 7.23 Төсвийн шууд захирагч нь ШУТИС Төвийн санхүүжилтийн эрхийг бусад эрх бүхий этгээдэд гэрээний үндсэн дээр шилжүүлж болно.


## 8. ШУТИС ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИЙН САНХҮҮГИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 8.1 Тайлант жилийн төсвийн санхүүжилт, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн эрдэм шинжилгээ, судалгааны орлогын эх үүсвэрийг ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци өөрийн орлого гэж хүлээн зөвшөөрнө.
- 8.2 Эрдэм шинжилгээний туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг борлуулсны орлого, гарааны компаниас төвлөрүүлэх орлого зэргийг ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци орлого гэж төлөвлөнө.

- 8.3 Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал хариуцсан газар, алба тухайн жилд бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн эрдэм шинжилгээний орлогын төлөвлөгөөний хуваарилалт гарган Хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн асуудал хариуцсан газар, албан д хүргүүлнэ.
- 8.4 Хичээлийн жилийн туршид бүх хэлбэрийн төслүүдээс нийт санхүүжилтийн 5 хувийг төсвийн төсөлд үндэслэн татан төвлөрүүлж, эрдэм шинжилгээ инновацийн үйл ажиллагааны зардал болон ШУТИС-ийн Захирлын зөвлөлөөр төвлөрүүлэн зарцуулах шийдвэр гаргасан бусад арга хэмжээний зардал зэргийг санхүүжүүлнэ.
- 8.5 ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн шийдвэр болон төвлөрүүлэх эрдэм шинжилгээ, судалгааны шимтгэлийг хуваарилагдах цаг хугацаандаа төвлөрүүлээгүй бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн эрдэм шинжилгээний төвлөрсөн үйлчилгээний зардлыг санхүүжүүлэхээс татгалзаж болно.
- 8.6 ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн шийдвэр болон төвлөрүүлэх эрдэм шинжилгээ, судалгааны шимтгэлийг заасан цаг хугацаандаа төвлөрүүлээгүй бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн төсвийн гүйцэтгэлийг хянах, шаардлагатай бол эрдэм шинжилгээ инновацийн зардлын гүйлгээг зогсоох хүртэл арга хэмжээ авах бөгөөд энэ тохиолдолд үүнээс үүсэх хохирлыг ШУТИС-ийн Захиргаа хариуцахгүй.
- 8.7 ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн шийдвэрээр, тодорхой арга хэмжээний зориулалтаар хуваарилагдсан орлогыг цаг тухай бүр, эсвэл улирал бүрийн санхүүгийн тайлагналын хугацаанд бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдтэй тооцоо нийлж тулган баталгаажуулна.
- 8.8 ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци нь төвлөрүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны орлого болон өөрийн орлогын эх үүсвэрээс бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдэд журмаас гадуур ямар нэг санхүүжилт болон эрдэм шинжилгээ, инновацийн зардлын гүйлгээний зориулалтыг өөрчлөн зарцуулалт хийж болохгүй.
- 8.9 ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци нь төсвийн гүйцэтгэл, төвлөрүүлсэн эрдэм шинжилгээний судалгааны орлогын бүрдүүлэлтийг ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хуралд тайлагнана.
- 8.10 ШУТИС Эрдэм шинжилгээ, инновацийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн шийдвэрийн дагуу ШУТИС Төвөөс тухайн жилийн нийт зардлын 10 хувиас ихгүй хэмжээгээр татаас санхүүжилт авч болно. Уг татаас санхүүжилтын зардлыг төсвийн тодотголоор баталж зарцуулалтыг хийнэ.
- 8.11 Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 6.6.3-ийн дагуу эрдэм шинжилгээ, инновацийн асуудал хариуцсан дэд захиралд эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалтын зардлын зарцуулалтын эрхийг хэсэгчлэн болон бүгдийг гэрээгээр шилжүүлэн өгч болно.
9. БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ, НЭГЖҮҮДИЙН САНХҮҮГИЙН ЭРХ, ҮҮРЭГ
- 9.1 Тайлант жилийн үндсэн үйл ажиллагааны орлого, үндсэн бус үйл ажиллагааны орлого, түрээс, тусламжийн орлого, санхүүжилтийн орлогын эх үүсвэрийг бүрэлдэхүүн сургууль, нэгжийн өөрийн орлого гэж хүлээн зөвшөөрнө.



- 9.2 Намрын сонгосон кредитээр тооцсон сургалтын төлбөрийг 10-р сарын 05-ны дотор, хаврын сургалтын төлбөрийг 3р сарын 05-ны дотор өөрийн дансанд төвлөрүүлнэ.
- 9.3 Бүрэлдэхүүн сургуулиуд сургалтын төлбөрийн орлогын данс, зардлын данс (бусад орлогын болон зардлын) гэсэн 2 төрлийн харилцах данстай байна.
- 9.4 Бусад бүрэлдэхүүн нэгжүүд орлого, зардлын гүйлгээ хийх нэг харилцах данстай байна.
- 9.5 Бакалавр, магистр, докторын болон өвөл, зуны сургалтын төлбөрийн орлого нь бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын төлбөрийн орлогын дансанд орно. Уг данснаас зарлагын гүйлгээ хийгдэхгүй. Шаардлагатай нөхцөлд бүрэлдэхүүн нэгжийн орлогын дансны эрхийг ШУТИС Төв нэгжид шилжүүлж болно.
- 9.6 Бүрэлдэхүүн сургуулиудын зардлын харилцах дансанд бакалавр, магистр, докторын сургалтын төлбөрөөс бусад ШУТИС-ийн Няглан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан бүх төрлийн орлого орно.
- 9.7 Бүрэлдэхүүн сургуулиуд зардлын дансанд орсон сургалтын төлбөрийн орлогыг ажлын 5 хоногийн дотор сургалтын төлбөрийн орлогын дансанд шилжүүлнэ.
- 9.8 Хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн асуудал хариуцсан газар, албаны баталсан бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын төлбөрийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг тухай бүр тайлagnana.
- 9.9 Бүрэлдэхүүн сургуулиуд сургалтын үйл ажиллагааны зардлаас бусад үйл ажиллагааны зардлыг өөрсдөө санхүүжүүлнэ. Үүнд: оюутны байр, төсөл, гэрээт ажил, түр сургалт, үйлдвэрлэл үйлчилгээ зэрэг багтана.
- 9.10 Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд хоорондоо өөрийн орлогын эх үүсвэрээс журмаас гадуур ямар нэг санхүүжилтийг хийж болохгүй.
- 9.11 Төлбөрөө тогтоосон хугацаанд төлбөрөө төлөөгүй оюутантай авлагын тооцоо хийж барагдуулах үүргийг бүрэлдэхүүн сургууль, нэгжийн удирдлага хүлээнэ. Авлагын хувь хэмжээг бүрэлдэхүүн сургууль, нэгжийн удирдлагын шийдвэрээр тайлан балансад тусгана.
- 9.12 Бүрэлдэхүүн сургууль, нэгжийн удирдлага зөвхөн сургалтын төлбөрөө бүрэн төлсөн оюутанд жилийн чөлөө олгох тушаал гаргах ба төлбөрөө төлж барагдуулаагүй оюутанд чөлөө өгснөөс болж үүссэн орлогын тасалдал, түүнээс үүсэх аливаа хүндрэлтэй асуудлыг бүрэн хариуцана.
- 9.13 Бусдад үзүүлсэн болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний тооцоог хичээлийн жилийн улирал бүрийн эцэст холбогдох журмын дагуу хийж байна.
- 9.14 Багш, ажиллагсдын хүн амын орлогын албан татвар, эрүүл мэнд нийгмийн даатгалтай холбогдсон тооцоог хуулийн дагуу тогтсон хугацаанд нь харьяа татварын болон нийгмийн даатгалын байгууллагатай бие даан хийнэ.
- 9.15 Бүрэлдэхүүн сургууль, нэгжийн удирдлага ба няглан бодогч нь цалин хөлс, түүнтэй адилтгах төлбөрийг тогтсон хугацаанд нь тавьж олгох, ажил үйлчилгээ явуулахдаа зардлын батлагдсан норм, нормативыг хэтрүүлэхгүй байх, худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээний үнэ тарифыг зах зээлийн дундаж үнээс хэтрүүлэхгүй байх, төлбөр тооцоог цаг тухайд нь хийж өр авлага үүсгэхгүй байх, зардлын зүйл ангийг батлагдсан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, төлбөрийн ээлж дарааллыг хатуу баримтлах, санхүү аж ахуйн




холбогдолтой мэдээ тайланг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж өгч байх зэрэг  
үүргийг хүлээнэ.

- 9.16 ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн шийдвэрээр, тодорхой арга хэмжээний зориулалтаар хуваарилагдсан орлогыг цаг тухай бүр, эсвэл улирал бүрийн санхүүгийн тайлагналын хугацаанд бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдтэй тооцоо нийлж тулган баталгаажуулна.
- 9.17 Бүрэлдэхүүн сургууль, нэгж нь сургалтын төлбөрийн өөрчлөлттэй холбогдсон санал тооцоог цаг тухайд нь гаргаж өгч байх, өртөг, зардлыг бууруулах боломж, үндэслэлийн талаар өөрсдийн саналыг холбогдох газар, албанад хүргүүлнэ.
- 9.18 Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан зааврын дагуу санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгыг хийх ба үүнд тайлант хугацааны орлого, зардал, бүтээгдэхүүний өртгийн тооцоо, зардлаас давсан орлогын тооцоог тус тус дэлгэрэнгүй тусгана.
- 9.19 Бүрэлдэхүүн сургууль, нэгж нь хөрөнгийн зарцуулалт, төсвийн гүйцэтгэлийг хамт олны хурлаар хэлэлцүүлж Санхүү, нягтлан бodoх бүртгэлийн асуудал хариуцсан газар, албанаас зарласан хуваарь, удирдамжийн дагуу ШУТИС-ийн Захиргааны зөвлөлийн хурлаар “Бүрэлдэхүүн сургууль, нэгжийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн шинжилгээ”-г хэлэлцүүлж, санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг тайлагнана.
- 9.20 Санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг бүрэлдэхүүн сургууль, нэгжийн удирдлагын шийдвэр, багш хамт олны хурлын тэмдэглэл, мөн энэ тухай товч тайлан болон нэгжийн санхүүгийн бие даасан байдлыг сайжруулах талаар гарсан холбогдох саналын хамт, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.
- 9.21 Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 6.6.3-ийн дагуу бүрэлдэхүүн нэгжийн удирдлагад сургалттай холбоотой шууд болон шууд бус зардал, оюутан үйлчилгээний зардал, эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалтын зардлын зарцуулалтын эрхийг хэсэгчлэн болон бүгдийг гэрээгээр шилжүүлэн өгч болно..

## 10. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

- 10.1 ШУТИС Төв, ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци, Захиргаа, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн тайланг нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль ба нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргаж Санхүү, нягтлан бodoх бүртгэлийн асуудал хариуцсан газар, албанад нэгтгүүлэн, нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланг гаргана.
- 10.2 ШУТИС Төв, ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци, Захиргаа, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүгийн тайлан нь Сангийн сайдын 2006 оны 11 сарын 27-ны өдрийн 388 тоот тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан, Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх зааварт үндэслэн боловсруулагдсан байна.
- 10.3 Санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна.
- Санхүүгийн байдлын тайлан
  - Санхүүгийн үр дүнгийн тайлан



- Цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан

10.4 Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

- Тухайн жилийн төсвийн орлого, төсвийн зарлагын гүйцэтгэл /Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогын ангилал, мөнгөн гүйлгээний тайлангийн зардлын ангилалын дагуу төрөл тус бүрээр, нийт дүнгээр, худалдан авах ажиллагааны бараа, ажил, үйлчилгээ тус бүрээр/
- Батлагдсан төсөв арга хэмжээ бүрээр зарцуулсан гүйцэтгэл, хүрсэн үр дүн /батлуулсан арга хэмжээний гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хийгдээгүй бол шалтгаан/
- Тайлагналыг санхүүгийн болон хичээлийн жилээр хийнэ.

10.5 ШУТИС Төв, ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци, Захиргаа, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн тайланг хүлээн авах тайлагнах хугацаа Монгол улсын Төсвийн тухай хуулийн цагалбартай ижил байна. ШУТИС Төв, ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци, Захиргаа, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд Санхүү, нягтлан бodoх бүртгэлийн асуудал хариуцсан газар, албан д жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор, Санхүү, нягтлан бodoх бүртгэлийн асуудал хариуцсан газар, алба нь төрийн аудитын байгууллагад нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангаа дараа оны 1 дүгээр сарын 25-ны дотор, төрийн захиргааны төв байгууллагад санхүүгийн тайланг 02 дугаар сарын 10-ны дотор, аудитлагдсан санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ.

10.6 ШУТИС Төв, ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци, Захиргаа, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-т заасны дагуу өнгөрсөн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын shilendans.gov.mn интернет хуудасд байрлуулж олон нийтэд мэдээлнэ.

10.7 ШУТИС Төв, ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци, Захиргаа, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд өнгөрсөн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд “Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн шинжилгээ хийх” удирдамжийн дагуу шинжилгээ хийн өөрсдийн хамт олны хурлаар 3 сарын 10-ны дотор, Санхүү, нягтлан бodoх бүртгэлийн асуудал хариуцсан газар, алба болон ШУТИС-ийн Захиргааны зөвлөлийн хурлаар 3 сарын 15-ны дотор, Санхүү, нягтлан бodoх бүртгэлийн асуудал хариуцсан газар, албанаас төсөв, санхүүгийн шинжилгээний үр дүнг нэгтгэн ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хурлаар 3 сарын 20-ны дотор тус тус хэлэлцүүлнэ.

10.8 Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн удирдлага хамтын олны хурлаар санхүүгийн тайлангийн шинжилгээ, санхүүгийн үр дүнгээ хэлэлцүүлнэ. ШУТИС-ийн Захиргааны зөвлөлийн хурлаар бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүгийн тайлангийн шинжилгээ, санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэж, ШУТИС-ийн нэгдсэн санхүүгийн тайлангийн шинжилгээ, санхүүгийн үр дүн, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдэд үр дүнгийн урамшуулал олгох тооцоо, бүрэлдэхүүн сургууль, нэгжийн үр дүнгийн урамшууллыг зарцуулах саналыг хэлэлцэнэ.

- 10.9 ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хурлаар бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүнтэй танилцаж, ШУТИС-ийн нэгдсэн санхүүгийн шинжилгээний үр дүнг хэлэлцэн, цаашид анхаарч ажиллах санал, зөвлөмжийг гаргана. Мөн бүрэлдэхүүн нэгжийн үр дүнгийн урамшуулал, үр дүнгийн урамшууллын зарцуулах зориулалт, санхүүгийн хувьд хүндрэлтэй бүрэлдэхүүн нэгжүүдэд олгох татаас зэрэг асуудлыг хэлэлцэж батална.
- 10.10 Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдэд ШУТИС Төвд төвлөрүүлсэн орлогын үлдэгдлийн хэмжээ, төсвийн зарлагын хэмнэлт, төсвийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байдлаас хамаарч урамшуулал олгох асуудлыг ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.
- 10.11 Энэхүү урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг тухайн жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн нэгжийн төсвийн тодотголоор эсвэл дараа жилийн төсөвт тусган Удирдах зөвлөлөөр батлуулна.
- 10.12 Төсвийн урамшууллыг дараах арга хэмжээнд зарцуулж болно.
- Бүрэлдэхүүн сургууль, нэгжийн үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий арга хэмжээнд
  - Бүрэлдэхүүн сургууль, нэгжийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх
  - Бүрэлдэхүүн сургууль, нэгжийн ажиллагсдын ажлын үр дүнг харгалзан урамшуулах
- 10.13 Төвлөрүүлсэн орлогоос давсан санхүүжилт хийгдсэн бүрэлдэхүүн сургуулиудын санхүүгийн үйл ажиллагааг ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, цаашид бүтцийн өөрчлөлт хийх зэрэг холбогдох бусад арга хэмжээний саналыг их сургуулийн Удирдах зөвлөлд оруулж хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

## 11. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

- 11.1 Төсвийн зардалд тусгагдсан сургалтын техник хэрэгсэл, тавилга эд хогшлыг худалдан авах, тэдгээрийг нийлүүлэх байгууллагыг холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулах асуудалд Захиргааны зүгээс хяналт тавина.
- 11.2 Бүрэлдэхүүн сургууль, нэгжийн удирдлага, ахлах нягтлан бодогч нарын хууль, тогтоомж, дотоод санхүүгийн дүрэм журмыг хэрэгжүүлэх ажилд санхүүгийн үйл ажиллагаа, хариуцаж буй асуудлаас хамаарч ШУТИС-ийн Захиргаа, Дотоод аудит, Хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлт, Хөрөнгө оруулалт, хангамж, Санхүү, нягтлан бodoх бүртгэлийн асуудал хариуцсан газар, албадууд хяналт тавих ба төсвийн хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зарлагад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах зэрэг арга хэмжээг авч ажиллана.
- 11.3 Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн ахлах нягтлан бодогч нар ШУТИС Төв, ШУТИС Эрдэм шинжилгээ, инновацийн төвлөрүүлэлтийн зардал, тооцоог тодорхой шалтгаангүйгээр шилжүүлээгүй, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн удирдлага батлагдсан төсөв болон энэхүү журмаар зааснаас өөр зориулалтаар өөрсдийн орлогын эх үүсвэрээс бусад бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдэд санхүүжилт хийсэн, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд Санхүү, нягтлан бodoх бүртгэлийн асуудал хариуцсан газар, албаны төсвийн

гүйцэтгэл, мэдээ, тайланг тогтоосон хугацаанд нь хүргүүлээгүй, санхүүгийн үйл ажиллагааны журмыг зөрчсөн бол ШУТИС-ийн Захиргаанаас зохих хууль, дүрэм, журмын дагуу сахилгын арга хэмжээ авна.

- 11.4 ШУТИС Төв, ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци, Захиргаа, бүрэлдэхүүн сургууль, нэгжийн удирдлага, ахлах нягтлан бодогч нар батлагдсан төсөвлөлтийн дагуу зарцуулалт хийгдээгүй, төсвийг зориулалтын бусаар зарцуулсан бол Төсвийн тухай хуульд заасны дагуу албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно.
- 11.5 Бүрэлдэхүүн нэгжийн сургалтын төлбөрийн орлого болон эрдэм шинжилгээний ажлын орлогын төлөвлөгөөг ханган ажиллаагүй бүрэлдэхүүн нэгжийн удирдлагад ШУТИС-ийн Захиргаанаас зохих хууль, дүрэм, журмын дагуу сахилгын хариуцлага тооцно.
- 11.6 ШУТИС-ийн санхүүгийн хяналт, шалгалтын үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн хүрээнд зохицуулагдана. ШУТИС Төв, ШУТИС Эрдэм шинжилгээ, инноваци, Захиргаа, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн батлагдсан төсөв төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд төсвийн гүйцэтгэл, зарцуулалтаар дотоод хяналтыг хэрэгжүүлэх ба энэ талаар шаардлагатай нөхцөлд Дотоод аудитын асуудал хариуцсан алба ШУТИС-ийн удирдлагаас гаргасан удирдамжийн дагуу хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.